



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 07 өдөр

Дугаар A/121

Биндэр сум

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биндэр сумын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний өргөмжлөл, медаль хэвлүүлэх зардалд 451,000 (дөрвөн зуун тавин нэгэн мянга) төгрөг, Биндэр ус, цаг уурын өртөөний бэлчээрийн даацын судалгаа хийх шатахууны зардалд 184,800 (нэг зуун наян дөрвөн мянга найман зуу) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 635,800 (зургаан зуун гучин таван мянга найман зуун) зардлыг засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН